



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/156

Сүхбаатар сум

Бүх нийтээр мод тарих ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны "Мод тарих үндэсний өдөр зарлах тухай" 63 дугаар зарлиг, 2013 оны "Засгийн газарт чиглэл өгөх тухай" 178 дугаар зарлигийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны "Мод тарих үндэсний өдөр зарлах тухай" 63 дугаар зарлигийн дагуу хаврын мод тарилтыг 2019 оны 05 дугаар сарын 11-ний өдөр аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.


2. Мод тарих ажлын төлөөлөгөө гаргах мод суулгах талбайг сонгох, хөрс боловсруулах, тарьц суулгацаар хангах, мод тарих, арчлах ажилд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг татан оролцуулах ажлыг ойн мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга, тосгодын захирагч нарт үүрэг болгосугай.

3. "Бүх нийтээр мод тарих өдөр"-өөр мод тарих иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, тарьсан модыг бүртгэлжүүлэн тайлагнаж ажиллахыг сумын болон сум дундын Ойн ангийн дарга нарт даалгасугай.

4. "Бүх нийтээр мод тарих өдөр"-өөр тарьсан модны тагаарх дэлгэрэнгүй тайлан мэдээ мэдээлэл, судалгааг хавсралт хүснэгтийн дагуу гаргаж 2019 оны 05 дугаар сарын 15-ны дотор Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлэхийг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

5. "Бүх нийтээр мод тарих өдөр"-ийн хүрээнд зохион байгуулсан ажлын тайлан, мэдээг нэгтгэж 2019 оны 05 дугаар сарын 20-ны дотор Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /З.Түвшинтөгс/-т даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

2019.05.11

“БҮХ НИЙТЭЭР МОД ТАРИХ ҮНДЭСНИЙ ӨДӨР”-ИЙН МЭДЭЭ



Сүхбаатар сум

Сумын нэр	Өрхийн тарьсан модны тоо		Аж ахуйн нэгж, байгууллагын тарьсан модны тоо		Баг, хороонд шинээр байгуулсан бичил, цэцэрлэг			Зүлжүүлэлт хийсэн талбай м²	Байгуулсан цэцгийн мандаг м²	Тарьсан модны тоо		Нийт таригдсан модны тоо	Мод тарьсан иргэдийн тоо	Мод тарьсан аж ахуй нэгж, байгууллагын тоо	Нийт зарцуулсан зардал /төг/
	Хашаандаа тарьсан модны тоо	Мод тарьсан өрхийн тоо	Орчин тойрсон, болон бичил цэцэрлэг, сэд, цэцэрлэгт хүрээлэнд тарьсан модны тоо	Байгуулагдсан нэрэмжит ой, төгөлд	Нэрэмжит ой, төгөлд	Шинээр байгуулсан бичил цэцэрлэгт	Талбайн хэмжээ /га/			Тарьсан модны тоо	Бүт, сөөгний тоо				

Тайлбар: Иргэд, ААН-ийн тарьсан мод, бут сөөг, цэцэрлэгжүүлсэн талбайн талаар тодорхой жишээ баримт, фото зургийг файлаар ирүүлэх.

Судалгаа гаргасан:

Хянасан: